



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 4/346

Мандалговь

Монголын бүх ард түмний спортын XV
наадамд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1.1, 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.7 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183, 2021 оны 268 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт, Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын 2022 оны А/17 дугаар тушаал болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 09 дугаар сарын 02 -ны өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын бүх ард түмний спортын XV наадамд оролцох Дундговь аймгийн баг тамирчдыг бэлтгэн оролцуулсугай.
2. Монголын бүх ард түмний спортын XV наадамд оролцоход шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах 12,460,400 (Арван хоёр сая дөрвөн зуун жаран мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111156